



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 168

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан 99,000,000.00 (ерөн есөн сая) төгрөгийн балансын үнэ, 5,775,000.00 (таван сая долоон зуун далан таван мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Монгол улсын Үндсэн хуулийн Цэцийн Захиргаа удирдлагын газрын дарга Г.Даваадалай, “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Ч.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаар, эзэмшигчийн гэрчилгээг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001417

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 05 дүгээр сарын 24 ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт



Монгол улсын Үндсэн хуулийн Цэцийн тамгын газрын
хөрөнгөд бүртгэлтэй Засгийн Газрын Авто Бааз УТҮГ-т балансаас
балансад шилжүүлэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ниссан Алтима, 0249УАА, арал № 1NBL4AP0LC192659	2020. 05	99,000,000.00	5,775,000.00	93,225,000.00
2	Нийт дүн				93,225,000.00 (ер өн гурван сая хоёр зуун хорин таван мянга)